



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛИЙН
РЕКТОРЫН ТУШААЛ

2025 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 4/29

Улаанбаатар хот

Дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрийг
батлах тухай

МУБИС-ийн дүрмийн 4.6.2, 4.6.8 дахь заалтууд, Ректорын зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хурлын тэмдэглэл, 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, Багшийн хөгжлийн хөтөлбөрийг хоёрдугаар хавсралтаар, Суралцагчийн хөгжлийн хөтөлбөрийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Дунд хугацааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг хөтөлбөр хариуцсан нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.
3. Хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн газрын захирал (Л.Мөнхтуяа)-д үүрэг болгосугай.

РЕКТОР



Ж.БАТБААТАР

Tushaal.doc

МУБИС-ИЙН СУРАЛЦАГЧИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР (2025-2027)

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Үндэслэл, хэрэгцээ

1.1.1 "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030 "МУБИС-ийн стратеги төлөвлөгөө", МУБИС-ийн "Сургалтын журам", МУБИС-ийн "Суралцагчийн журам", хичээлийн хөтөлбөрүүд болон суралцагчийн хөгжлийн үйл ажиллагаатай холбоотой бодлогын болон эрх зүйн баримт бичгүүд нь хөтөлбөрийн үндэслэл болно.

1.1.2 МУБИС-ийн багш бэлтгэх хөтөлбөрийн шинэчлэл, сургалтад оролцогч талуудын үүрэг оролцооны шинэ хандлага, чанартай багш бэлтгэх бүхий л үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын үндсэн цөм нь суралцагчийн хөгжилд суурилах ба мэргэжлийн болоод бие хүний мэдлэг, чадварын хувьд суралцагчийг цогцоор хөгжүүлэх шаардлагатай байна.

1.2 Хэрэгжүүлэх зарчим

1.2.1 Суралцагчийн хөгжлийн бодлого үйл ажиллагаа нь боловсролын хөгжлийн бодлого, үндсэн чиглэлд суурилан багш боловсролын нэр хүндийг өсгөж, ажил олгогч, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн багш, бусад салбарын мэргэжилтнийг бэлтгэх, нийгэмд зөв хандлага төлөвшүүлэхэд чиглэсэн байх;

1.2.2 Суралцагчийн хөгжлийн бодлого нь шударга, ил тод байдал, хүний эрх, эрх чөлөө, жендерийн тэгш байдлыг хангаж, хүртээмжтэй, суралцагчийн сэтгэл ханамжид нийцсэн байх;

1.2.3 Суралцагч бүрийг мэргэжлийн болон хувь хүний ур чадвартай, сэтгэл зүй, гоо зүйн боловсролтой, харилцааны болон ёс зүйн хэм хэмжээний хувьд цогцоор хөгжих орчин бүрдүүлэхэд чиглэх;

1.2.4 Суралцагчийн сурах үйл ажиллагааг болон судалгаа шинжилгээний ажил, санаачилгыг сургуулийн зүгээс тасралтгүй, тогтвортой дэмжих;

1.2.5 Суралцагчийн хөгжлийн хөтөлбөр нь суралцагч, Оюутны холбоо, оюутны асуудал хариуцсан МУБИС-ийн бүрэлдэхүүний сургуулийн болоод алба нэгж, удирдлага, тэнхим багш нарын хамтын ажиллагаанд суурилсан байх;


1.2.6 Суралцагчийн нийгмийн халамж, үйлчилгээний хүртээмж, үр өгөөжийг сайжруулах, суралцагчийг сургуулийн орчинд болон сургуулиас гадуур хөдөлмөр эрхлэх боломжоор хангах;

1.2.7 Суралцагчийн нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлж, сайн дурын үндсэн дээр үйл ажиллагааг зохион байгуулахыг эрхэмлэх;

1.3 Нэр томьёо

1.3.1 Суралцагч: МУБИС-ийн богино хугацааны сургалт, бакалавр, магистр, докторын бүх түвшний, бүх хэлбэрийн гадаад, монгол суралцагчид;

1.3.2 Оюутны хөгжлийн нэгж: Суралцагчийн хөгжил, үйлчилгээ, суралцагчтай холбоотой асуудал эрхэлсэн бүтцийн нэгж;



ХОЁР. ЗОРИЛГО, ЗОРИЛТ

2.1 **Зорилго:** МУБИС-ийн суралцагчийг зөв хандлага төлөвшилтэй, мэргэжлийн мэдлэг, чадвартай, өөрийн удирдлагатай суралцаж, боловсролын болон бусад шинжлэх ухааны салбарын манлайлагч мэргэжилтэн бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх, нэгдсэн бодлого үйл ажиллагаагаар хангахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

2.2 Суралцагчийн хөгжлийн хөтөлбөрийн зорилтууд

Зорилт 1. Суралцагчийн санаачилгыг дэмжих, хөгжих боломжийг бүрдүүлэх;

Зорилт 2. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чадвар төлөвшүүлэх;

Зорилт 3. Хувь хүний хөгжлийг дэмжих;

Зорилт 4. Халамж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах;

Зорилт 5. Нийгмийн идэвх оролцоог дэмжих;

Зорилт 6. Цахим шилжилт, цахим үйлчилгээг нэмэгдүүлэх;

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

3.1 МУБИС-ийн төвлөрсөн ба бүрэлдэхүүний болон салбар сургуулиудын төсөв;

3.2 Олон улсын байгууллага, хандивлагчдын тусламж, хандив;

3.3 Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж;

3.4 Хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр;

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

4.1 "Суралцагчийн хөгжлийн хөтөлбөр"-ийг удирдлага, төлөвлөлтөөр хангах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах үүргийг Оюутны асуудал эрхэлсэн нэгж, санхүүжүүлэх үүргийг Санхүү, хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн нэгж, хянах үнэлэх үүргийг Сургалт, хамтын ажиллагаа эрхэлсэн проректор хүлээнэ.

4.2 "Суралцагчийн хөгжлийн хөтөлбөр"-ийн хэрэгжүүлэх бодлого, зорилт, холбогдох дүрэм, журам, шаардлагатай төсөв, хөрөнгө оруулалтыг Ректорын зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

4.3 "Суралцагчийн хөгжлийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг Оюутны асуудал эрхэлсэн нэгж, тус нэгжийн чиг үүргийг бүрэлдэхүүний болон салбар сургуульд хэрэгжүүлэгч ажилтан, хөтөлбөрийн албад, тэнхим багш нартай хамтран зохион байгуулж ажиллана.

4.4 "Суралцагчийн хөгжлийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг мөн хөтөлбөрийн баримтлан Оюутны асуудал эрхэлсэн нэгж болон бүрэлдэхүүн, салбар сургуулийн хөтөлбөрийн албад боловсруулж МУБИС-ийн сургалт, хамтын ажиллагаа эрхэлсэн проректор хянаж батална.

ТАВ. СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ БОЛОН ЗОРИЛТОТ ТҮВШИН, СТРАТЕГИ

Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин /2024 он/	Зорилтот түвшин /2028 он/	Санхүүгийн эх үүсвэр
Суралцагчийн санаачилгыг дэмжих, хөгжих боломж нөхцөлийг бүрдүүлэх	Суралцагчийн санаачилсан сайн дурын болон олон нийтийн аливаа үйл ажиллагаанд орчин нөхцөл, санхүү, бодлогын дэмжлэг үзүүлэх	Чанар: Нийт сургалтын танхимыг хичээлийн бус цагаар оюутны клубүүдэд ашиглуулах	Оюутны сайн дурын клубүүд үйл ажиллагаа явуулах танхимаар хангаж өгдөг.		
	Суралцагчийн үзэл бодлоо илэрхийлэх, сургуулийн болон сургалтын үйл ажиллагаатай холбоотой зүй ёсны санал, хүсэлт, санаалчилгыг дэмжих, бодитой ажил хэрэг болгох, МУБИС-ийн алба, нэгж, бүрэлдэхүүний болон салбар сургууль үйл ажиллагаанд тусгах	Чанар: Оюутны санал, гомдлын шийдвэрлэлт нэмэгдэнэ.	Суралцагч гомдол саналаа зөвхөн бичгээр гаргадаг.	Суралцагчийн гомдол саналыг бичгээр хүлээн авахаас гадна СУМС-ийн "Тусламж, үйлчилгээ" цэсээр дамжуулан цахим хэлбэрээр авч шийдвэрлэх	

	Суралцагч суралцагчдаа эерэг сайнаар нөлөөлөх, мэргэжлийн болон хувь хүний сайн туршлагаа бусдад түгээх, уриалах боломж нөхцөлийг бүрдүүлэх	Тоо: Клубүүдийн үйл ажиллагааны 40 хүртэл хувийг суралцагч суралцагчдаа нөлөөлөх үйл ажиллагаанд чиглүүлнэ.	Оюутны сайн дурын клубээр дамжуулан хийгддэг.	МУБИС-ийн Оюутны холбоо, зөвлөл, сайн дурын клубүүдийн үйл ажиллагааны дийлэнх хувийг нөлөөллийн үйл ажиллагаа байхаар зохион байгуулах	МУБИС-ийн төвлөрсөн ба бүрэлдэхүүний болон салбар сургуулиудын төсөв
Сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чадвар төлөвшүүлэх	Шинээр элсэгчдэд суралцахуйн дэмжлэг үзүүлэх, сурлагын хоцрогдолтой суралцагчдын судалгааг гаргаж, дэмжлэг үзүүлэх	Тоо: Хичээлийн жилд 2 удаа	Зарим сургуулийн хөтөлбөрийн албанд хийгддэг.	Бүрэлдэхүүний сургууль болон мэргэжлийн тэнхимтэй хамтрах, оюутанд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх	
	Суралцагч, багш, Оюутны хөгжлийн нэгж, Эрдэм шинжилгээний нэгжийн хамтын ажиллагааг сайжруулж, суралцагч бүрийг эсээ, илтгэл, төсөл, бичил судалгааны ажил бичих чадварт суралцуулах	Тоо: Жилд 1-2 клуб, дугуйлан ажиллуулах	Бүрэлдэхүүний болон салбар сургуулийн хөтөлбөрийн албанаас сургалт зохион байгуулдаг.	Эрдэм шинжилгээний нэгж болон Оюутны хөгжлийн нэгж хамтран сургалт зохион байгуулах, оюутны клуб, дугуйлан ажиллуулах, эсээ, илтгэл, төсөл бичих заавар бүхий цахим хичээлүүд цувралаар бэлтгэж хүргэх	МУБИС-ийн төвлөрсөн ба бүрэлдэхүүний болон салбар сургуулиудын төсөв

	Суралцагч сайн дурын болон мэргэжлийн клубүүдийн үйл ажиллагааг дэмжиж, илтгэх урлаг, мэтгэлцээн, мэргэжлийн туршилт болон арга зүйд суралцагчдыг суралцуулах	Тоо: Суурь түвшингээс 1-3 хүртэл хувиар нэмэгдүүлэх	Оюутны сайн дурын 48 клуб үйл ажиллагаа явуулж байна.	Оюутны мэргэжлийн клубийн тоог нэмэгдүүлэх, сайн дурын клубийн тоог суурь түвшингээс бууруулахгүй байх	МУБИС-ийн төвлөрсөн ба бүрэлдэхүүн ий болон салбар сургуулиудын төсөв
	Суралцагч судалгааны ажлынхаа үр дүнгээр бүтээл туурвих, дадлага, лабораторийн үйл ажиллагаагаар аливааг зохион бүтээх, инновац үйлдвэрлэх, зохиогчийн эрх авах боломжийг бүрдүүлэн дэмжих	Тоо: Жилд 1 бүтээлд зохиогчийн эрх авах зорилт тавин ажиллах	Зохиогчийн эрх авсан бүтээл бүртгэгдээгүй	Суралцагчдын судалгааны ажлыг дэмжих, бүтээлд зохиогчийн эрх авах боломжийг бүрдүүлэх	МУБИС-ийн төвлөрсөн ба бүрэлдэхүүн ий болон салбар сургуулиудын төсөв
	Багш суралцагчийн хамтын судалгаа, шинжилгээний ажилд бодлогын болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх, судалгааны багт ажиллах боломжоор хангах	Тоо: Суурь түвшингээс жил бүр 3-5% өсгөнө	Оюутны судалгааны төсөлд бакалаврын 36, докторантын 5 суралцагч хамрагдсан. Нийт 17 сая төгрөг санхүүжүүлсэн. Багш, оюутны хамтарсан төсөлд 18 суралцагч	Суурь түвшнээс жил бүр 3-5% өсгөнө	МУБИС-ийн төвлөрсөн ба бүрэлдэхүүн ий болон салбар сургуулиудын төсөв

			оролцсон.		
	Суралцагчийн төрөл бүрийн бүтээлийг олон нийтэд сурталчлан таниулж, алдаршуулах	Чанар: Суралцагчдын бүтээлийн үзэсгэлэнд бүрэлдэхүүний болон салбар сургууль бүрийн оролцоог хангах	МУБИС-ийн хэмжээнд жилд 1 удаа, ДУТС-ийн хэмжээнд 2-3 удаа үзэсгэлэн гаргадаг.	Суралцагчдын бие даасан болон хамтарсан үзэсгэлэн гаргах, олон нийтэд сурталчлах МУБИС-ийн хамтын ажиллагаатай гадаадын их сургуулиудтай хамтарсан үзэсгэлэнг танхимаар болон виртуал хэлбэрээр гаргах	МУБИС-ийн төвлөрсөн ба бүрэлдэхүүний болон салбар сургуулиудын төсөв
Хувь хүний хөгжлийг дэмжих	Бүрэлдэхүүний болон салбар сургуулиудын хөтөлбөрийн албад, тэнхим, багш нарын нөөц боломжид тулгуурлан хичээлийн бус цагаар суралцагчдын авьяас сонирхлын дагуу сонгон, секц, дугуйланд хамрагдах боломжоор хангах	Бүрэлдэхүүний болон салбар сургууль бүр ядаж нэг сонгон, секц, дугуйланг санаачлан ажиллуулах	БоСС, НХУС-ийн хүрээнд хэрэгждэг.	Бүрэлдэхүүний болон салбар сургууль бүр ядаж нэг сонгон, секц, дугуйланг санаачлан ажиллуулах	МУБИС-ийн төвлөрсөн ба бүрэлдэхүүний болон салбар сургуулиудын төсөв

	Бүрэлдэхүүний болон салбар сургуулиудын хичээлийн байр, оюутны байр, номын сан зэрэгт үйл ажиллагаа явуулдаг “Оюутны хөгжлийн төв”-ийн тоог нэмэгдүүлэх, байнгын үйл ажиллагааг оюутны сэтгэл ханамжид нийцүүлэх Суралцагчдыг сонирхлын бүлгээрээ хамтран сайн дурын болон мэргэжлийн клуб байгуулан ажиллуулах боломжийг бүрдүүлэх, дэмжлэг үзүүлэх	Чанар: Оюутны хөгжлийн төв бүрийн интернэт орчин, цэвэр ус, агааржуулалт, суудлын тооны хүртээмжийг нэмэгдүүлж, тав тухийг сайжруулах, талбайн хэмжээг томруулах	Хичээлийн 1 дүгээр байр, БТС, НХУС, МБУС, СӨБС, ДУТС, БС болон оюутны дотуур байруудад “Оюутны хөгжлийн төв” тохижуулсан.	АРА БС, БөБС, БoCC-ийн хичээлийн болон дотуур байранд “Оюутны хөгжлийн төв” тохижуулах	МУБИС-ийн төвлөрсөн ба бүрэлдэхүүн ий болон салбар сургуулиудын төсөв
	Нийгэм, соёлын зүтгэлтнүүд болон иргэд олон нийтийн төлөөллүүдтэй уулзалт, ярилцлага, сургалт, семинар зохион байгуулж, суралцагчид соёл, мэргэжлийн болон хувь хүний зөв үлгэр дуурайлал, дадал хэвшил төлөвшүүлэх, сайн туршлагыг судлах боломж нөхцөлөөр хангах	Тоо: Хөтөлбөр бүрийн төгсөгчдийг хамруулах	Бүрэлдэхүүний болон салбар сургууль бүр жилд 1-2 уулзалт зохион байгуулдаг.	Сэдэв, мэргэжлийн чиглэлээс хамааруулан хичээлийн жилд 2-4 удаагийн уулзалт зохион байгуулах Уулзалтуудыг цахим контент болгон түгээх	МУБИС-ийн төвлөрсөн ба бүрэлдэхүүн ий болон салбар сургуулиудын төсөв


	Соёлч байдал, хууль тогтоомжийн хэрэгжилт, амьдралын эрүүл зөв дадал хэвшлийн аян, хөдөлгөөн өрнүүлж хувийн соёл, багшийн соёл, ажлын байранд гараад ажил олгогчийн шаардлагад нийцэх, хамт олны соёлд богино хугацаанд дасах дадал, хэвшилтэй болгох	Чанар: Аяны хэрэгжилтийн хүрээнд суралцагчид зөв дадал хэвших, шинэ мэдлэг мэдээллээр хангагддаг байх	МУБИС-ийн эрүүл мэндийн төвөөс жил бүр 1 сарын аян зохион байгуулдаг.	Намар, хаврын улиралд 2 удаа аяныг зохион байгуулах	МУБИС-ийн төвлөрсөн ба бүрэлдэхүүн ий болон салбар сургуулиудын төсөв
	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын хөгжил, хэрэгцээ шаардлага, суралцах болон өөрийгөө хөгжүүлэх, бусдад нөлөөлөх бүх талаар дэмжлэг үзүүлэх, тусгайлсан үйл ажиллагаа зохион байгуулах	Чанар: Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын орчны сэтгэл ханамжийг үнэлдэг болох	Хичээлийн жилд 1 удаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж, нөхцөл илрүүлэх судалгаа авдаг.	Уулзалт хэлэлцүүлгийг уламжлал болгон зохион байгуулах, нөхцөл илрүүлэх судалгааны өгөгдлийн санд анализ хийж, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлтөд тусгах Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг тэгш хамруулах нөлөөллийн үйл ажиллагааг төрөл бүрээр зохион байгуулах	МУБИС-ийн төвлөрсөн ба бүрэлдэхүүн ий болон салбар сургуулиудын төсөв

	Сургалтын хөтөлбөрийн хүрээнд болон бусад үйл хамтын ажиллагааны хүрээнд гадаад, дотоодын их сургуулиудын суралцагч солилцооны хөтөлбөрт хамрагдах, солилцооны хөтөлбөрт хамрагдсан бусад суралцагч, багшаас сайн туршлага солилцох боломжийг бүрдүүлэх	Чанар: Хамтарсан хөтөлбөрийн солилцооноос гадна оюутны соёлын солилцоог нэмэгдүүлэх, Бүрэлдэхүүний болон салбар сургуулийн хооронд урт болон богино хугацааны солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх	177 суралцагч БНХАУ, Япон	Суралцагч солилцооны хөтөлбөрт хамрагдсан суралцагчийн тоог нэмэгдүүлэх Солилцоонд хамрагдсан суралцагчдын сайн туршлага судлах өдөрлөг зохион байгуулах	МУБИС-ийн төвлөрсөн ба бүрэлдэхүүн ий болон салбар сургуулиуды н төсөв Олон улсын байгууллага, хандивлагчдын тусламж, хандив
	Жил бүрийн элсэгчдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулан, эрүүл амьдрах дадал хэвшилд сургах		438 суралцагч эрт илрүүлэгт хамрагдсан.	Элсэгч бүрийг эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	
Дэмжлэг, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах	Суралцагчийн олон улс, тив, дэлхийд үзүүлсэн онцгой амжилт, ололт, инновац технологийн үр дүн, нээлт, эрхлэн хэвлүүлсэн ном, зохиол бүтээл, олны хүртээл болгосон контент, аним зэргийг дэмжих, урамшуулах, сургалтын тэтгэлэгт хамруулах	Тоо: Тэтгэлэгт хамрагдсан оюутны тоо		Бүрэлдэхүүний сургууль бүрээс онцгой ажилт гаргасан суралцагчдыг тэтгэлэгт хамруулах	МУБИС-ийн төвлөрсөн ба бүрэлдэхүүн ий болон салбар сургуулиуды н төсөв Олон улсын байгууллага,

					хандивлагчдын тусламж, хандив
	МУБИС-ийн хүрээнд тулгамдаж буй аливаа асуудлыг шийдвэрлэх загварчлал, оновчлол, мэдээллийн технологийн шийдэл боловсруулж, үйл ажиллагаанд нэвтрүүлэх туршилтын үр дүн амжилттай батлагдсан тохиолдолд худалдан авах, дэмжих	Тоо: Төслийн тоо		Тодорхой мэргэжлийн хөтөлбөрөөр суралцагчдын дунд МУБИС-ийн хүрээнд тулгамдаж буй аливаа асуудлыг шийдвэрлэх загварчлал, оновчлол, мэдээллийн технологийн шийдэл боловсруулах төслийн уралдаан зохион байгуулах	МУБИС-ийн төвлөрсөн ба бүрэлдэхүүний болон салбар сургуулиудын төсөв
	“Орлоготой оюутан” хөтөлбөрийг хэрэгжүүлж, дотооддоо болон гадны байгууллага аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах	Тоо: Хамрагдсан оюутны тоо	125 суралцагч	Нийт суралцагчдын 1-3 хувийг хамруулах	МУБИС-ийн төвлөрсөн ба бүрэлдэхүүний болон салбар сургуулиудын төсөв
	Төгсөх түвшний суралцагчдыг ажлын байранд зуучлах, ажил	Тоо: Хөдөлмөр эрхлэлтийн хувь	Жилд 1 удаа зохион байгуулдаг.	Уламжлал болгон зохион байгуулах, төгсөгчдийн	

	олгогчтой харилцаа холбоо тогтоох, мэдээ мэдээллээр хангах			статистик мэдээллийг МУБИС- ийн веб сайтад нээлттэй байршуулах	
Нийгмийн идэвх оролцоог дэмжих	Суралцагчийн авьяасыг нээн хөгжүүлж, урлагийн арга хэмжээнүүдийг зохион байгуулж, “МУБИС-ийн урлагийн их наадам”-ыг хийх	Чанар: Наадмын төрөл, оюутны оролцоо	Жилд 1 удаа зохион байгуулдаг.	Бүрэлдэхүүний болон салбар сургуулийн хэмжээнд бага наадам зохион байгуулж, шалгарсан суралцагчдын дунд их наадмыг зохион байгуулах	МУБИС-ийн төвлөрсөн ба бүрэлдэхүүн ий болон салбар сургуулиуды н төсөв
	Оюутны авьяасыг нээн хөгжүүлж, спортын арга хэмжээнүүдийг зохион байгуулан, “МУБИС-ийн спортын их наадам”-ыг хийх	Чанар: Наадмын төрөл, оюутны оролцоо	Жилд 1 удаа зохион байгуулдаг.	Бүрэлдэхүүний болон салбар сургуулийн хэмжээнд бага наадам зохион байгуулж, шалгарсан суралцагчдын дунд их наадмыг зохион байгуулах	МУБИС-ийн төвлөрсөн ба бүрэлдэхүүн ий болон салбар сургуулиуды н төсөв
	Аливаа тэмдэглэлт баяр ёслолын үеэр суралцагч, багш нар болон нийгэмд чиглэсэн арга хэмжээнүүд зохион байгуулж олон нийтэд сурталчлах	Чанар: Үйл ажиллагааны төрөл, оюутны оролцоо	Дээлтэй Монгол өдөр, ДЭМБ-аас зарласан тэмдэглэлт өдрүүдийн 2-3 арга хэмжээ зохион байгуулдаг.	Монгол өв соёл, уламжлалын 2-3 үйл ажиллагаа, ДЭМБ- аас зарласан тэмдэглэлт өдрийн 2-3 үйл ажиллагаа, Олон улсын оюутны	МУБИС-ийн төвлөрсөн ба бүрэлдэхүүн ий болон салбар

				эрхийн өдөр, МУБИС-ийн хүрээний тэмдэглэлт өдрүүдэд зориулсан үйл ажиллагаа зохион байгуулах	сургуулиуды н төсөв
	Суралцагчийн авьяасыг хөгжүүлэх сонгон, секц, дугуйлангийн сургалтын үр дүнг тооцон, авьяас чадвартай оюутнуудыг дотоодын их сургууль хоорондын болон гадаадын уралдаан тэмцээнүүдэд оролцуулах	Чанар: Үйл ажиллагааны төрөл, оюутны оролцоо	Багшлахуйн ур чадварын олимпиад, Эрдэм шинжилгээний хурлууд зохион байгуулдаг.	Уралдаан тэмцээний төрлийг нэмэгдүүлэх, Их дээд сургуулиуд болон хамтын ажиллагаатай гадаадын их дээд сургуулийн уралдаан тэмцээнд оролцогчдын тоог нэмэгдүүлэх	МУБИС-ийн төвлөрсөн ба бүрэлдэхүүн ий болон салбар сургуулиуды н төсөв
	Сайн дурын клубүүдийн үйл ажиллагааны хүрээнд нийгэмд чиглэсэн сайн үйлсийн аян, нөлөөллийн арга хэмжээнүүдийг зохион байгуулж олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр байнга сурталчлах	Тоо: Хамрагдсан оюутны тоо	Жилд 2-3 үйл ажиллагааг нийгэмд чиглэсэн байдлаар зохион байгуулдаг. Мод тарих Их цэвэрлэгээ Цусны хандив	Сайн дурын үйл ажиллагаа хичээлийн хүрээнд оюутны клубүүдтэй хамтран үйл ажиллагааны чиглэл, тоог нэмэгдүүлэх	МУБИС-ийн төвлөрсөн ба бүрэлдэхүүн ий болон салбар сургуулиуды н төсөв

Цахим шилжилт, суралцагчид чиглэсэн үйлчилгээ	Цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, оюутны үнэмлэх, тодорхойлолт, бүх төрлийн лавлагааг цахимаар олгох	Тоо: Цахим хэлбэрт шилжсэн үйлчилгээний тоо, хэрэглэгчийн тоо	Сурдаг нь үнэн болон дүнгийн тодорхойлолт СУМС-аас хэвлэдэг. Цахим оюутны үнэмлэхтэй.	Сургалтын төлбөр төлөлтийн задаргаа, санхүүгийн төлөвлөлт Сурлагын амжилт, хөтөлбөр, бүрэлдэхүүний болон салбар сургууль, МУБИС-ийн хэмжээний дүнгийн ранк Шилжилт хөдөлгөөн, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагддаг эсэх лавлагаа Оюутны хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан лавлагаа Сайн дурын үйл ажиллагааны оролцооны лавлагаа зэргийг суралцагчид олгох	 МУБИС-ийн төвлөрсөн ба бүрэлдэхүүн ий болон салбар сургуулиудын төсөв
	Суралцагчийн гомдол, санал хүсэлтийг цахимаар авч, түргэн шуурхай шийдвэрлэн цахимаар хариуг илгээх	Тоо: Цахим хэлбэрт шилжсэн үйлчилгээний тоо, хэрэглэгчийн тоо		"Тусламж, үйлчилгээ" цэсээр дамжуулан Сургалтын нэгж, оюутны хөгжлийн нэгж, Ёс зүйн хороо, Сэтгэл зүйн	МУБИС-ийн төвлөрсөн ба бүрэлдэхүүн ий болон салбар

				үйлчилгээний төвийн үйлчилгээг цахимаар авах	сургуулиудын төсөв
	Суралцагчийн аливаа сэтгэл ханамжийн судалгаа, санал асуулгад цахимаар оролцох боломжийг нэмэгдүүлэх	Тоо: Цахим хэлбэрт шилжсэн үйлчилгээний тоо, хэрэглэгчийн тоо	Google forum-д байршуулсан судалгааны линкийг СУМС-д зарлал хэлбэрээр байршуулдаг.	Оюутны хөгжлийн нэгжээс авдаг судалгааны асуулга, боловсруулалтын үр дүнгүүдийг СУМС-д байршуулах, боловсруулалтыг систем хийж, үр дүнгээр өгөгдлийн сан үүсгэх, сангийн өгөгдөлд анализ хийдэг байх	МУБИС-ийн төвлөрсөн ба бүрэлдэхүүний болон салбар сургуулиудын төсөв
	Суралцагч өөрийн "Суралцахуй болон хувь хүний хөгжлийн төлөвлөгөө"-г цахимаар төлөвлөж, хэмжих боломжийг нээх	Тоо: Цахим хэлбэрт шилжсэн үйлчилгээний тоо, хэрэглэгчийн тоо		Суралцагч бүрд сургалтын хөтөлбөрийн "Санал болгох төлөвлөгөө"-г СУМС-д байршуулан санал болгодгийн адил Оюутны хөгжлийн нэгжээс "Суралцахуй болон хувь хүний хөгжлийн төлөвлөгөө"-г боловсруулах байршуулж, оюутны	МУБИС-ийн төвлөрсөн ба бүрэлдэхүүний болон салбар сургуулиудын төсөв

				чөлөөт сонголттой болгох	
	Багшийн харилцаа, хандлагыг суралцагч цахимаар үнэлж, санал өгөх	Чанар: Багшийн ёс зүй, харилцаа хандлагатай холбоотой оюутны гомдол буурах, сэтгэл ханамж дээшлэх	Багшийн сургалтын үйл ажиллагааг суралцагч цахимаар үнэлдэг.	Багшийн ёс зүй, харилцаа хандлагыг үнэлдэг болох	МУБИС-ийн төвлөрсөн ба бүрэлдэхүүн ий болон салбар сургуулиуды н төсөв
	Хиймэл оюун ухаан суурилсан цахим үйлчилгээ, лавлагаа	Тоо: Цахим хэлбэрт шилжсэн үйлчилгээний тоо, хэрэглэгчийн тоо		СУМС-ийн оюутны системийг хиймэл оюун ухаанд суурилсан өгөгдлийн шинжилгээ болон VOICE хэлбэрт шилжүүлэх Түгээмэл асуултууд болон их хэрэглэгддэг үйлчилгээг хиймэл оюун ухаанд хөрвүүлэх Хиймэл оюун ухаанд суурилсан операторын үйлчилгээг нэвтрүүлэх	МУБИС-ийн төвлөрсөн ба бүрэлдэхүүн ий болон салбар сургуулиуды н төсөв

	СУМС-ийн модулиудыг гар утасны аппликейшин болгож хөгжүүлэх	Тоо: Цахим хэлбэрт шилжсэн үйлчилгээний тоо, хэрэглэгчийн тоо		СУМС-ийн Оюутны систем болон Элсэлтийн нэгдсэн санг апп болгон хөгжүүлэх	МУБИС-ийн төвлөрсөн ба бүрэлдэхүүн ий болон салбар сургуулиудын төсөв
--	---	---	--	--	---

ЗУРГАА. ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮЛХҮҮР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

МУБИС-ийн Стратеги төлөвлөгөө /2025-2030/-ний ахиц дэвшлийг дараах гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтээр хэмжих бөгөөд жил бүрийн гүйцэтгэлийг дараах байдлаар тодорхойлж байна.

Стратеги /арга зам/	Суурь түвшин /2024 он/	Түлхүүр	2025	2026	2027
Суралцагчийн хөгжлийн хөтөлбөрийн тухайн жилийн хэрэгжилтийн хувь	86.3%	Оюутны хөгжлийн нэгжийн тайлангийн гүйцэтгэл	80%	82%	84%
МУБИС-ийн суралцагчдаас авах оюутны хөгжил, үйлчилгээний сэтгэл ханамжийн хувь	78.4%	Оюутны хөгжлийн нэгж сэтгэл ханамжийн судалгааг жил бүр авах	80%	82%	84%
Суралцагч суралцагчдаа эерэг сайнаар нөлөөлөх, мэргэжлийн болон хувь хүний сайн туршлагаа бусдад түгээх, уриалах боломж нөхцөлийг бүрдүүлэх	Оюутны сайн дурын клубээр дамжуулан хийгддэг.	Тухайн хичээлийн жилд үйл ажиллагаа явуулсан клубүүдийн нийт үйл ажиллагааны тоонд нөлөөллийн үйл ажиллагааны эзлэх хувь	35%	38%	40%
Суралцагч, багш, Оюутны хөгжлийн нэгж, Эрдэм шинжилгээний нэгжийн хамтын ажиллагааг сайжруулж, суралцагч бүрийг эсээ, илтгэл, төсөл, бичил судалгааны ажил бичих чадварт суралцуулах	Бүрэлдэхүүний болон салбар сургуулийн хөтөлбөрийн албанаас сургалт зохион байгуулдаг.	Эрдэм шинжилгээний нэгж, Оюутны хөгжлийн нэгж хамтран оюутны клуб, дугуйлан үүсгэж, сургалт зохион байгуулах тоо	1-2	2-3	3-4
Суралцагч сайн дурын болон мэргэжлийн клубүүдийн үйл ажиллагааг дэмжиж, илтгэх урлаг, мэтгэлцээн, мэргэжлийн туршилт болон арга зүйд суралцагчдыг суралцуулах	Оюутны сайн дурын 48 клуб үйл ажиллагаа явуулж байна.	Мэргэжлийн болон сайн дурын клубийн тоо	48	50	52

Суралцагч судалгааны ажлынхаа үр дүнгээр бүтээл туурвих, дадлага, лабораторийн үйл ажиллагаагаар аливааг зохион бүтээх, инновац үйлдвэрлэх, зохиогчийн эрх авах боломжийг бүрдүүлэн дэмжих	Зохиогчийн эрх авсан бүтээл бүртгэгдээгүй	Зохиогчийн эрх авсан бүтээлийн тоо	1-2	2-3	3-4
Багш суралцагчийн хамтын судалгаа, шинжилгээний ажилд бодлогын болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх, судалгааны багт ажиллах боломжоор хангах	Оюутны судалгааны төсөлд бакалаврын 36, докторантын 5 суралцагч хамрагдсан. Нийт 17 сая төгрөг санхүүжүүлсэн. Багш, оюутны хамтарсан төсөлд 18 суралцагч оролцсон.	Нийт эрдэм шинжилгээ судалгааны төсвийг суурь түвшнээс нэмэгдүүлэх хувь	2-3%	3-4%	4-5%
Суралцагчийн төрөл бүрийн бүтээлийг олон нийтэд сурталчлан таниулж, алдаршуулах	МУБИС-ийн хэмжээнд жилд 1 удаа, ДУТС-ийн хэмжээнд 2-3 удаа үзэсгэлэн гаргадаг.	Тухайн хичээлийн жилд МУБИС-ийн хэмжээний болон мэргэжлийн онцлогтой тэнхимээс гаргасан, дотоодын болон гадаадын нийт хамтарсан үзэсгэлэнгийн тоо	1-2	2-3	3-4
Бүрэлдэхүүний болон салбар сургуулиудын хөтөлбөрийн албад, тэнхим, багш нарын нөөц боломжид тулгуурлан хичээлийн бус цагаар суралцагчдын авьяас сонирхлын дагуу сонгон, секц, дугуйланд хамрагдах боломжоор хангах	БоСС, НХУС-ийн хүрээнд хэрэгждэг.	Нийт МУБИС-ийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах дугуйлан секцийн тоо	9	10-12	12-14

Бүрэлдэхүүний болон салбар сургуулиудын хичээлийн байр, оюутны байр, номын сан зэрэгт үйл ажиллагаа явуулдаг “Оюутны хөгжлийн төв”-ийн тоог нэмэгдүүлэх, байнгын үйл ажиллагааг оюутны сэтгэл ханамжид нийцүүлэх Суралцагчдыг сонирхлын бүлгээрээ хамтран сайн дурын болон мэргэжлийн клуб байгуулан ажиллуулах боломжийг бүрдүүлэх, дэмжлэг үзүүлэх	Хичээлийн 1-р байр, БТС, НХУС, МБУС, СӨБС, ДУТС, БС болон оюутны дотуур байруудад “Оюутны хөгжлийн төв” тохижуулсан.	Оюутны хөгжлийн төвгүй сургуулиудад байгуулах	1-2	2-3	3
Нийгэм, соёлын зүтгэлтнүүд болон иргэд олон нийтийн төлөөллүүдтэй уулзалт, ярилцлага, сургалт, семинар зохион байгуулж, суралцагчид соёл, мэргэжлийн болон хувь хүний зөв үлгэр дуурайлал, дадал хэвшил төлөвшүүлэх, сайн туршлагыг судлах боломж нөхцөлөөр хангах	Бүрэлдэхүүний болон салбар сургууль бүр жилд 1-2 уулзалт зохион байгуулдаг.	Хичээлийн жил бүрд нийт бакалаврын багц хөтөлбөр бүрээс нэг төгсөгчийг сонгон авч суралцагчтай уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах	38	40	42
Соёлч байдал, хууль тогтоомжийн хэрэгжилт, амьдралын эрүүл зөв дадал хэвшлийн аян, хөдөлгөөн өрнүүлж хувийн соёл, багшийн соёл, ажлын байранд гараад ажил олгогчийн шаардлагад нийцэх, хамт олны соёлд богино хугацаанд дасах дадал, хэвшилтэй болгох	МУБИС-ийн эрүүл мэндийн төвөөс жил бүр 1 сарын аян зохион байгуулдаг.	Аяны хүрээнд хичээлийн жил бүр тодорхой дадлыг суралцагчдад хэвшүүлэхийг зорино. Хэвшүүлбэл зохих дадлын тоо	2	4	6
Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын хөгжил, хэрэгцээ шаардлага, суралцах болон өөрийгөө хөгжүүлэх, бусдад нөлөөлөх бүх талаар дэмжлэг үзүүлэх, тусгайлсан үйл ажиллагаа зохион байгуулах	Хичээлийн жилд 1 удаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж, нөхцөл илрүүлэх судалгаа	Хэлэлцүүлэгт хамрагдах суралцагчийн хувь	60%	70%	80%

	авдаг. 2024 онд 62 суралцагчаас 36 суралцагч хэлэлцүүлэгт хамрагдсан.				
Сургалтын хөтөлбөрийн хүрээнд болон бусад үйл хамтын ажиллагааны хүрээнд гадаад, дотоодын их сургуулиудын суралцагч солилцооны хөтөлбөрт хамрагдах, соёлын солилцооны хөтөлбөрт хамрагдсан бусад суралцагч, багшаас сайн туршлага солилцох боломжийг бүрдүүлэх	177 суралцагч БНХАУ, Япон	Солилцооны хөтөлбөрт хамрагдагсдын тоо суурь түвшин болон өмнөх жилээсээ нэмэгдэх хувь	3%	5%	8%
Жил бүрийн элсэгчдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулан, эрүүл амьдрах дадал хэвшилд сургах	438 суралцагч эрт илрүүлэгт хамрагдсан.	Нийт элсэгчдээс эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдагсдын хувь	50%	65%	80%
Суралцагчийн олон улс, тив, дэлхийд үзүүлсэн онцгой амжилт, ололт, инновац технологийн үр дүн, нээлт, эрхлэн хэвлүүлсэн ном, зохиол бүтээл, олны хүртээл болгосон контент, аним зэргийг дэмжих, урамшуулах, сургалтын тэтгэлэгт хамруулах		Тэтгэлэгт хамрагдагсдын нийт бакалаврын суралцагчдад эзлэх хувь	0,5%	1%	1,5%
МУБИС-ийн хүрээнд тулгамдаж буй аливаа асуудлыг шийдвэрлэх загварчлал, оновчлол, мэдээллийн технологийн шийдэл боловсруулж, үйл ажиллагаанд нэвтрүүлэх туршилтын үр дүн амжилттай батлагдсан тохиолдолд худалдан авах, дэмжих		Төслийн тоо	1-2	2-3	3-4

“Орлоготой оюутан” хөтөлбөрийг хэрэгжүүлж, дотооддоо болон гадны байгууллага аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах	125 суралцагч	Орлоготой оюутан хөтөлбөрт хамрагдагсдын тоо суурь түвшин болон өмнөх жилээсээ нэмэгдэх хувь	10%	15%	20%
Төгсөх түвшний суралцагчдыг ажлын байранд зуучлах, ажил олгогчтой харилцаа холбоо тогтоох, мэдээ мэдээллээр хангах	Жилд 1 удаа зохион байгуулдаг.	Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь	80-85%	85-90%	90-95%
Суралцагчийн авьяасыг нээн хөгжүүлж, урлагийн арга хэмжээнүүдийг зохион байгуулж, “МУБИС-ийн урлагийн их наадам”-ыг хийх	Жилд 1 удаа зохион байгуулдаг. 4 төрлөөр зохион байгуулсан	Урлагийн наадмын үзүүлбэрийн төрлийн тоо	6	8	10
Оюутны авьяасыг нээн хөгжүүлж, спортын арга хэмжээнүүдийг зохион байгуулан, “МУБИС-ийн спортын их наадам”-ыг хийх	Жилд 1 удаа зохион байгуулдаг.	Спортын наадмын төрлийн тоо	4	5	6
Аливаа тэмдэглэлт баяр ёслолын үеэр суралцагч, багш нар болон нийгэмд чиглэсэн арга хэмжээнүүд зохион байгуулж олон нийтэд сурталчлах	Дээлтэй Монгол өдөр, ДЭМБ-аас зарласан тэмдэглэлт өдрүүдийн 2-3 арга хэмжээ зохион байгуулдаг.	Үйл ажиллагааны төрлийн тоо	5	8	10
Суралцагчийн авьяасыг хөгжүүлэх сонгон, секц, дугуйлангийн сургалтын үр дүнг тооцон, авьяас чадвартай оюутнуудыг дотоодын их сургууль хоорондын болон гадаадын уралдаан тэмцээнүүдэд оролцуулах	Багшлахуйн ур чадварын олимпиад, Эрдэм шинжилгээний хурлууд зохион байгуулдаг.	Оролцсон оюутны тоо нь тухайн бүрэлдэхүүний сургуулийн нийт суралцагчдад эзлэх хувь	1-3%	3-5%	5-7%

Сайн дурын клубүүдийн үйл ажиллагааны хүрээнд нийгэмд чиглэсэн сайн үйлсийн аян, нөлөөллийн арга хэмжээнүүдийг зохион байгуулж олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр байнга сурталчлах	Жилд 2-3 үйл ажиллагааг нийгэмд чиглэсэн байдлаар зохион байгуулдаг. Мод тарих Их цэвэрлэгээ Цусны хандив	Сайн үйлсийн аян, нөлөөллийн арга хэмжээний тоо	3-4	5-6	7-8
Цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, оюутны үнэмлэх, тодорхойлолт, бүх төрлийн лавлагааг цахимаар олгох	Сурдаг нь үнэн болон дүнгийн тодорхойлолт СУМС-аас хэвлэдэг. Цахим оюутны үнэмлэхтэй.	Өмнөх үйлчилгээнд шинээр нэмэгдэх цахим үйлчилгээний тооны нийлбэр	4	5	6
Суралцагчийн гомдол, санал хүсэлтийг цахимаар авч, түргэн шуурхай шийдвэрлэн цахимаар хариуг илгээх		Цахимаар ирсэн гомдол саналын шийдвэрлэлт, хариу мэдэгдлийн хувь	70%	80%	90%
Суралцагчийн аливаа сэтгэл ханамжийн судалгаа, санал асуулгад цахимаар оролцох боломжийг нэмэгдүүлэх	Google forum-д байршуулсан судалгааны линкийг СУМС-д зарлал хэлбэрээр байршуулдаг.	Цахимаар авсан судалгааны тоо	3 хүртэл	5 хүртэл	7 хүртэл
Суралцагч өөрийн суралцахуй болон хувь хүний хөгжлийн төлөвлөгөөг цахимаар төлөвлөж, хэмжих боломжийг нээх		Суралцахуй болон хувь хүний хөгжлийн төлөвлөгөөг цахимаар төлөвлөсөн суралцагчдын нийт суралцагчдад эзлэх хувь- Төлөвлөгөөгөө цахимаар хийсэн суралцагчдын гүйцэтгэлийн хувь	30%: 40%	40%:5 0%	60%:7 0%

Багшийн харилцаа, хандлагыг суралцагч цахимаар үнэлж, санал өгөх	Багшийн сургалтын үйл ажиллагааг суралцагч цахимаар үнэлдэг.	Үнэлгээг хичээлийн жилд авах тоо	1	2	2
Хиймэл оюун ухаан суурилсан цахим үйлчилгээ, лавлагаа		Хиймэл оюун ухаанд суурилсан үйлчилгээний тоо	0	0	1
СУМС-ийн модулиудыг гар утасны аппликейшин болгож хөгжүүлэх		Хөгжүүлсэн аппын тоо	0	0	1

ДОЛОО. ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ

7.1 Жил бүрийн 08 дугаар сард Оюутны хөгжлийн нэгж хөтөлбөрийн хэрэгжилтийг хичээлийн жилээр хийж, өөрийн үнэлгээний тайлан боловсруулна.

7.2 Жил бүрийн 09 дүгээр сард хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг Ректорын зөвлөлөөр оруулан хэлэлцүүлж, санал дүгнэлт гаргуулна.

7.3 Өөрийн үнэлгээний тайлангийн санал зөвлөмж, Ректорын зөвлөлөөс өгсөн зөвлөмж зэргийг дараагийн хичээлийн жилийн хөтөлбөрийн хэрэгжилтийн төлөвлөгөөнд тусгаж ажиллана.